



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын ҮАГазрын харьяа Увс аймгийн аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан.



**Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.**

Өлгий сумын төсвийн байгууллагуудын 2014, 2015 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүн

УВААГ- 2016/06 -НА

2016 оны 09 дугаар сар

УВААГ-2016/06-НА

|                                                                                                                                                       |                                                                                                                                                                                    |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| <b>Тайлан бэлтгэсэн:</b>                                                                                                                              | Агуулга                                                                                                                                                                            | 3  |
| <b>Дарга, тэргүүлэх аудитор</b><br>Б.Авирмэд                                                                                                          | Товчилсон үгийн тайлал                                                                                                                                                             | 4  |
| <b>Аудитын менежер</b><br>Ж.Энхжаргал                                                                                                                 | Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй                                                                                                                                           | 5  |
| <b>Ахлах аудитор</b><br>С.Алтанхундага                                                                                                                | <b>Бүлэг 1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.</b>                                                                                                             | 6  |
| <b>Аудитор</b><br>М.Бат-Амгалан                                                                                                                       | 1.1.Батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргаагүй байна.                                                                                                                       | 6  |
| <b>Шинжээч</b><br>Л.Бат-Очир                                                                                                                          | 1.2. Сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоондоо багтаан ажилласан байна.                                                                                                   | 6  |
|                                                                                                                                                       | 1.3. Ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдлийг олгоогүй байна.                                                                                                                | 7  |
|                                                                                                                                                       | 1.4.Төсөвт байгууллагуудын өр нэмэгдэж, авлагыг барагдуулан ажилласан байна.                                                                                                       | 8  |
| 2016 оны 9 дүгээр сар                                                                                                                                 | 1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлахгүйгээр материал бэлтгэн нийлүүлжээ.                           | 8  |
|                                                                                                                                                       | 1.6. Ахлах сургуулийн “багш хөгжлийн төв”-д ирсэн компьютерүүд бүрэн ашиглагдаж байгаа эсэх нь тодорхойгүй төрийн хөрөнгө бусдад ашиглагдах, үрэгдэх эрсдэл үүсэж болзошгүй байна. | 9  |
|                                                                                                                                                       | 1.7.Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт хангалтгүй байна.                                                                                                                       | 10 |
| Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317, 7045-3721, 7045-4721 дугаарын утсаар харилцана уу. | <b>Бүлэг 2. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.</b>                                                                                                     | 11 |
|                                                                                                                                                       | 2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.                                                                                                               | 11 |
|                                                                                                                                                       | 2.2.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгасан байна.                                                                                                  | 11 |
|                                                                                                                                                       | 2.3. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 590.0 мянган төгрөгийг акт барагдаагүй байна.                                                                                          | 11 |
|                                                                                                                                                       | 2.4. Мэдээллийн самбарт шилэн дансны мэдээллийг байршуулжээ.                                                                                                                       | 12 |
| <b>Хаяг:</b><br>Увс аймгийн Аудитын газар<br>Улаангом сум 3 дугаар баг<br>аймгийн Засаг даргын тамгын газрын байр                                     | <b>Бүлэг 3. Эмийн эргэлтийн сангаас зориулалт бус зардал гаргажээ.</b>                                                                                                             | 13 |
|                                                                                                                                                       | 3.1. 2015 онд Эргэлтийн эмийн сан алдагдалтай ажиллажээ.                                                                                                                           | 13 |
|                                                                                                                                                       | 3.2.Эмийн худалдан авалтыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.                                                                                                             | 13 |
|                                                                                                                                                       | 3.3.Эргэлтийн эмийн сантай холбоотой өглөг авлагыг бүрэн тайлагнасан байна.                                                                                                        | 13 |
|                                                                                                                                                       | 3.4.Эргэлтийн эмийн сангаас Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардалд хөрөнгө зарцуулсан байна.                                                                                 | 14 |
|                                                                                                                                                       | Холбогдох байгууллагын санал                                                                                                                                                       | 15 |
|                                                                                                                                                       | Аудитын газраас өгөх тайлбар                                                                                                                                                       | 16 |
|                                                                                                                                                       | Дүгнэлт                                                                                                                                                                            | 17 |
|                                                                                                                                                       | Зөвлөмж                                                                                                                                                                            | 18 |

**Товчилсон үгийн тайлал:**

ИТХурал – Иргэдийн төлөөлөгчдийн хурал

ЗДТГазар -Засаг даргын тамгын газар

ЭМТөв – Эрүүл мэндийн төв

ХХОАТ-ын –Хувь хүний орлогын албан татварын

ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

Монгол Улсын Үндэсний аудитын газрын харъяа Увс аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өлгий сумын төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд нийцлийн аудит хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь Өлгий сумын төсөвт байгууллагууд төсөв санхүүжилт болон хөрөнгө нөөцөө үр ашигтай, үр дүнтэй, хууль тогтоомжийн хүрээнд зарцуулж байгаа эсэх, өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд хэрэгжсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, үр нөлөөг дээшлүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал зөвлөмж боловсруулж хүргүүлэхэд оршино.

### **Хамарсан хүрээ**

Аудитыг Өлгий сумын төсөвт байгууллагын 2014, 2015 он, Эмийн эргэлтийн сангийн 2014- 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулан хийж гүйцэтгэв.

### **Арга зүй**

Аудит хийхдээ асуудлын шинжилгээний арга зүйн дагуу гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан анхан шатны баримтыг тулгах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Энэхүү нийцлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, Үндэсний аудитын газрын харъяа Увс аймгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын баталсан нийцлийн аудитын төлөвлөгөөг мөрдөж ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Нийцлийн аудитыг Монгол Улсын Үндэсний аудитын газрын харъяа Увс аймгийн Аудитын газрын ахлах аудитор С.Алтанхундага, шинжээч Л.Бат-Очир, нар 2016 оны 09 сарын 16–наас, аудитор М.Бат-Амгалан 9 сарын 20-ноос 09-р сарын 24-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

## Бүлэг 1

### Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

#### 1.1. Батлагдсан төсвөөс зориулалт бус зардал гаргаагүй байна.

Өлгий сумын төсөвт байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл дараах байдалтай байна. Үүнд:

| Байгууллагын нэр                       | Төлөвлөгөө  | 2014 он     |                  |             | /мянган төгрөгөөр/ 2015 он |                  |
|----------------------------------------|-------------|-------------|------------------|-------------|----------------------------|------------------|
|                                        |             | Гүйцэтгэл   | хэтрэлт, хэмнэлт | төлөвлөгөө  | Гүйцэтгэл                  | хэтрэлт, хэмнэлт |
| ИТХурал                                | 45,405.0    | 44,099.1    | 1,305.9          | 38,773.7    | 35,520.4                   | 3,253.3          |
| ЗДТГазар                               | 395,199.5   | 395,429.8   | (230.3)          | 262,149.9   | 248,721.4                  | 13,428.5         |
| ЭМТөв                                  | 310,056.2   | 309,752.3   | 303.9            | 295,935.9   | 293,600.8                  | 2,335.1          |
| Ахлах сургууль<br>Хүүхдийн<br>цэцэрлэг | 770,961.5   | 771,083.6   | (122.1)          | 739,606.1   | 706,655.1                  | 32,951.0         |
|                                        | 222,747.7   | 222,747.5   | 0.2              | 230,012.7   | 213,870.3                  | 16,142.4         |
| Соёлын төв                             | 53,629.5    | 53,354.4    | 275.1            | 59,401.0    | 54,676.0                   | 4,725.0          |
| Бүгд дүн                               | 1,797,999.4 | 1,796,466.7 | 1,532.7          | 1,625,879.3 | 1,553,044.0                | 72,835.3         |

2014 онд батлагдсан төсөвт зардлыг сумын дүнгээр 1532,7 мянган төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан боловч ЗДТГазар 230,3 мянга, Ахлах сургууль 122,1 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна. Гэтэл 2015 онд сумын дүнгээр 72835,3 мянган төгрөгөөр төсөвт зардлыг хэмнэлттэй зарцуулснаар тайлагнасан ч санхүүжилт ондоо багтаж олгогдоогүйгээс оны эцэст 75121,7 мянган төгрөгийн өглөгтэй гарчээ.

Сумын төсөвт байгууллагуудын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, баримтын бүрдүүлэлт, эмх цэгц сайн байна.

#### 1.2. Сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоондоо багтан ажилласан байна.

Өлгий сумын төсөвт байгууллагууд батлагдсан бүтэц, орон тоондоо багтан үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

| Байгууллагын нэр | Төлөвлөгөө | 2014 он   |                  |            | /мянган төгрөгөөр/ 2015 он |                  |
|------------------|------------|-----------|------------------|------------|----------------------------|------------------|
|                  |            | Гүйцэтгэл | хэтрэлт, хэмнэлт | төлөвлөгөө | Гүйцэтгэл                  | хэтрэлт, хэмнэлт |
| ИТХурал          | 2          | 2         | -                | 2          | 2                          | -                |
| ЗДТГазар         | 18         | 18        | -                | 29         | 29                         | -                |
| ЭМТөв            | 26         | 26        | -                | 25         | 25                         | -                |

УВААГ-2016/06-НА

|                   |     |     |   |     |     |   |
|-------------------|-----|-----|---|-----|-----|---|
| Ахлах сургууль    | 68  | 68  | - | 68  | 68  | - |
| Хүүхдийн Цэцэрлэг | 22  | 22  | - | 22  | 22  | - |
| Соёлын төв        | 9   | 9   | - | 9   | 9   | - |
| Бүгд дүн          | 145 | 145 | - | 155 | 155 | - |

Төсвийн тухай хуулийн 16.5.3.-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу сумын төсөвт байгууллагууд батлагдсан орон тоогоороо ажилласан хэдий ч ЗДТГазар, Эрүүл мэндийн төвөөс бусад төсөвт байгууллагууд оны эхэнд албан тушаал, ажилтнуудын ажилласан жил, цалингийн сүлжээ, шатлал, үндсэн цалин, нэмэгдэлийн хувь хэмжээг тогтоож баталсан тушаал шийдвэр гаргаагүй байна.

Сумын Засаг даргын 2014 оны Б/01 тушаалаар 2014 онд ЗДТГазрын ажиллах бүтэц орон тоо, албан тушаалын жагсаалтыг батлахдаа Газрын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалыг баталсан байна. Гэтэл Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2014 оны 35 тоот тушаалаар “Гээзэгтэй овогтой Анхбаярыг Өлгий сумын газрын даамлаар 2014 оны 01-р сарын 02-ны өдрөөс томилсугай”, “Газрын даамлаар томилогдсон Г.Анхбаярыг өдөр тутмын удирдлагаар ханган батлагдсан төсвийн хүрээнд ТЗ-3-ын зохих шатлалаар төрийн албан хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл бусад холбогдох зардлыг тус тус тооцон олгож ажиллахыг сумын ЗДТГ-ын дарга Ш.Дүүрэнбилэгт зөвлөсүгэй” гэсэн Г.Отгонболдын тушаалаар Өлгий сумын ЗДТГазарт газрын даамлаар ажилд орж, тухайн байгууллагын удирдлагын шийдвэргүйгээр ЗДТГ-аас цалинжиж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.4.15-д “аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга тухайн шатны Засаг даргын Тамгын газрын төсвийн шууд захирагч байна” гэж заасантай зөрчилдөж байна.

### 1.3. Ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдлийг олгоогүй байна.

Төсөвт байгууллагууд оны эхэнд ажилтнуудын цалин хөлс, нэмэгдлийг тогтоосон шийдвэр гаргаагүйгээс зарим хүмүүсийн ур чадварын нэмэгдэл, зэргийн нэмэгдэл, зэрэг дэв, удаан жилийн нэмэгдлийг урьд жилүүдэд гарсан тушаалаар үргэлжлүүлэн олгожээ. Энэ нь Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4-р хавсралтын 2,8 дахь заалтыг зөрчиж байна. Цаашид ур чадварын нэмэгдэл болон бусад нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу олгож байхыг зөвлөмж болголоо.

Засгийн газрын болон яам, аймаг сумын шагналаар шагнагдсан ажилтнуудад ур чадварын нэмэгдлийг шагналын чанараас шалтгаалан улирал, хагас, бүтэн жилээр олгожээ. Тухайлбал: Эрүүл мэндийн төв Эрүүл мэндийн тэргүүний ажилтан тэмдгээр шагнагдсан хүнд үндсэн цалингийн 20 хувиар 1 жил, ЭМЯамны жуух бичгээр шагнагдсан хүнд 20 хувиар хагас жил, сумын ЭМ тэргүүний ажилтанаар шагнагдсан хүнд 25 хувиар улирлаар ур чадварын нэмэгдлийг байгууллагын дотоод журамд зааснаар олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 142 тоот тогтоолоор баталсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтны дагалдах мөнгөн шагналын хэмжээ”, 1997 оны 53 тоот тогтоолоор баталсан “Яам агентлагаас олгох шагналын нийтлэг

тодорхойлолт, дагалдах мөнгөн шагналын хэмжээ” тогтоосон шийдвэрүүдийг тус тус зөрчсөн байна.

Иймд байгууллагын дотоод журмыг хууль, тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулахыг зөвлөмж болголоо.

Сангийн сайдын 2014 оны 55 тоот тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал батлах тухай” заавар журмыг зөрчин Ахлах сургууль цалингийн зардлаас тэтгэвэрт гарсан 2 хүнд 1077.5 мянган төгрөгийн буцалтгүй тусламж олгосон байна.

#### **1.4. Төсөвт байгууллагуудын өр нэмэгдэж, авлагыг барагдуулан ажилласан байна.**

2015 оны 7 сард Л.Янжмаа, З.Нэргүй нарт 20,0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон боловч суутгаж аваагүй, авлагаар бүртгээгүй байсанд урьдчилгааг суутгаж авлагыг барагдуулахыг зөвлөмж болголоо.

Сумын төсөвт байгууллагууд 2014 онд 6545,9 мянга, 2015 онд 75121,7 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарч 2014 оны 30150,0 мянган төгрөгийн авлагыг 2015 ондоо барагдуулж авлагын үлдэгдэлгүй болсон байна.

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр  | 2013 оны эцэст |        | 2014 оны эцэст |          | 2015 оны эцэст |        |
|-------------------|----------------|--------|----------------|----------|----------------|--------|
|                   | өглөг          | авлага | өглөг          | авлага   | өглөг          | авлага |
| ИТХурал           | 5.8            |        |                |          | 2,282.6        |        |
| ЗДТГазар          | 6,540.1        |        | 25,000.0       | 29,989.9 | 9,845.4        |        |
| ЭМТөв             |                |        |                | 160.1    |                |        |
| Ахлах сургууль    |                |        |                |          | 45,850.4       |        |
| Хүүхдийн цэцэрлэг |                |        |                |          | 16,957.1       |        |
| Соёлын төв        |                |        |                |          | 186.2          |        |
| Бүгд дүн          | 6,545.9        | -      | 25,000.0       | 30,150.0 | 75,121.7       | -      |

2015 онд санхүүжилтийн эрхийг нээж өгөөгүйгээс 75121,7 мянган төгрөгийн өглөлтэй гарчээ.

#### **1.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлахгүйгээр материал бэлтгэн нийлүүлжээ.**

Цахилгааны түгээх сүлжээ ХХК-ний төлбөрийн нэхэмжлэхэд Засаг даргын тамгын газар 2014 оны 9,10 сар, 2015 оны 7 сараас хойш, Эрүүл мэндийн төв 2014 оны 8 сараас хойш, 2015 онд 4,5,11 сараас бусад саруудад, Ахлах сургууль 2014, 2015 оны 11 сараас бусад саруудад, Соёлын төв 2015 оны 10, 11, 12-р сараас бусад саруудын тоолуурын заалтыг бичээгүй байна. Тоолуурын заалтыг бичээгүй нэхэмжлэлээр төлбөр гүйцэтгэж байгаа нь үнэн бодит хэрэглэсэн гэрэл цахилгааны төлбөр төлж байгаа эсэхийг нотлох боломжгүй байна.

Эрүүл мэндийн төв авто машины бензин шатахууныг сумын шатахуун түгээх станцаас зөвшөөрлийн бичгээр буюу зээлээр авч сарын эцэст тооцоо УВААГ-2016/06-НА

хийж төлбөрийг гүйцэтгэж байна. Жолоочийн замын хуудсыг хөтөлж, тооцоог сар бүр Монгол улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 тоот тушаалаар батлагдсан **“Авто машины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”**-ыг мөрдөж бүсийн болон хүйтний нэмэгдлийг оруулан тооцож бодсон боловч гадны машинд бензин, шатахуун олгохдоо норм хэмжээг тооцоогүй байна. ЗДТГазрын жолооч явсан тухай бүрдээ замын хуудсыг хөтлөхгүйгээр нөхөж хөтөлсөн, шатахуун зарцуулалтын тооцоог нягтлан бодогч бодоогүй, гадны машинд бензин, шатахуун олгохдоо норм хэмжээг баримтлахгүйгээр олгосон байна. Харин өөрийн авто машингүй төсөвт байгууллагууд бензин шатахуун зарцуулахдаа зөвшөөрлийн бичгээр тооцож төлсөн ба шатах тослох материал олгосон жагсаалт үйлдээгүй, ня-бо тооцоог бодоогүй байна.

Төсөвт байгууллагууд шатах, тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүйгээс шатахуун олгох зөвшөөрлийн жижиг тасалбар үрэгдвэл хэн ямар ажилд хэдэн литр шатахуун авсан нь тодорхойгүй болох эрсдэл ажиглагдаж байна. Байгууллагын нярав нар бензин шатахууныг хэнд, хэдэн литрийг ямар зориулалтаар олгосон тухай жагсаалт үйлдэж шатахуун хүлээн авсан хүнээр гарын үсэг зуруулж тайланд хавсаргаж байхыг зөвлөж байна.

**1.6. Ахлах сургуулийн “багш хөгжлийн төв”-д ирсэн компьютерүүд бүрэн ашиглагдаж байгаа эсэх нь тодорхойгүй төрийн хөрөнгө бусдад ашиглагдах, үрэгдэх эрсдэл үүсэж болзошгүй байна.**

Аудитын явцад хөрөнгийн хэсэгчилсэн тооллого хийхэд Хүүхдийн цэцэрлэг 88.0 мянган төгрөгийн люмниторг 2 дахин бүртгэсэн байсныг хөрөнгөөс хасаж бүртгэхийг зөвлөмж болгов. Ахлах сургуулийн багш хөгжлийн төвд олгосон notebook-үүдийг зарим багш нар хувийн хөрөнгө мэтээр ашиглаж зарим нь хаана байгаа нь тодорхойгүй байгаа нь төрийн хөрөнгө бусдад ашиглагдах, үрэгдэх эрсдлийг бий болгож байна. Цаашид компьютерүүдийг кодоор тулган бүртгэхийг аудитын явцад зөвлөлөө.

Ахлах сургуулийн дотуур байрны хүүхдийн тоог хоолны почёнкаар тулган баталгаажуулахад 2015 онд 298 хүүхэд буюу 689.8 мянган төгрөгийн хоолны зардлыг илүү зарлагдсаныг сургуулийн няраваар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөх олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламжийг чөлөөлнө” гэсэн заалтыг зөрчин тэтгэвэрт гарсан багш Ё.Дэмчиг, номын санч Ч.Моголцог нарт 1077.5 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо 169.4 мянган төгрөгийн татвар, шимтгэл суутгажээ. Цаашид хууль тогтоомжийг мөрдөж ажиллахыг зөвлөмж болголоо.

**1.7. Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт хангалтгүй байна.**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.3.1-д “Худалдах, шилжүүлэх устгах эд хөрөнгийн талаар Өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх” гэж заасан байна.

Гэтэл ЗДТГазар 2015 онд Очирбатаас 350,0 мянга, Даваахүүгээс 600,0 мянган төгрөгөөр 2 ширхэгийг нийт 3 худгийн мотор худалдан авсан ба хуучин ашиглагдаж байсан худагны моторууд ажиллахгүй болсон шалтгааныг техникийн

УВААГ-2016/06-НА



акт үйлдэхгүйгээр шинэчлэн тавьсан байна. Цаашид техник хэрэгсэл эвдэрч ажиллахгүй болсон тохиолдолд байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр дүгнэлт гаргуулж ажиллахыг зөвлөмж болгов.

Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн даргын тушаалын архивын нэгж болгосон баримтанд тушаалын хавсралтуудыг хавсаргаагүй байна. Цаашид архивын баримт бичгийг хууль, тогтоомжийн дагуу бүрдүүлж, эмх цэгцтэй байдлыг ханган ажиллахыг зөвлөлөө.

## Бүлэг 2

### **Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.**

#### **2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байна.**

Өлгий сум 2014, 2015 онд сумын конторын барилгад их засвар хийж тохижуулсан, хуучин ашиглагдахгүй байсан ахуй үйлчилгээний барилгыг засаж тохижуулан зочид буудал болон үйлчилгээний төв болгосон, сумын төвийн гэрэлтүүлэг, авто машины зогсоолын талбай байгуулсан, хуучин ашиглагдахгүй байсан складыг худалдан авч засвар тохижилт хийсэн, наадмын талбай байгуулан зүлэгжүүлж тохижуулсан, Улсын баатар Б.Гивааны хөшөө, хүндэтгэлийн талбай бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулсан, ЗДТГазар шинэ машинтай болсон, иргэний танхим тохижуулсан, Эрүүл мэндийн төвд чийрэгжүүлэлтийн танхим тохижуулсан, сумын төвд ундны ус цэвэршүүлэх төхөөрөмж тавьсан зэрэг 406,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгджээ.

2014 онд ЗДТГазар 247129,6 мянга, ИТХурал 108,9 мянга, Эрүүл мэндийн төв 1498,0 мянга, Ахлах сургууль 15986,6 мянга, Хүүхдийн цэцэрлэг 1934,4 мянга, Соёлын төв 2918,6 мянга нийт 269576,1 мянга, 2015 онд ЗДТГазар 73046,3 мянга, Эрүүл мэндийн төв 4360,0 мянга, Ахлах сургууль 51584,8 мянга, Хүүхдийн цэцэрлэг 4655,6 мянга, Соёлын төв 3000,0 мянга нийт 136646,7 мянган төгрөгийн авто машин, агуулах, хөшөө, техник, тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нэмэгдсэн байна.

#### **2.2.Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг бодитой дүгнэж, данс бүртгэлд тусгасан байна.**

Хөрөнгө оруулалтаар Өлгий сумын төсөвт байгууллагууд 2014 онд 269576,1 мянга, 2015 онд 136646,7 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнийг данс бүртгэлд тусгасан байна.

#### **2.3. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн 590.0 мянган төгрөгийг акт барагдаагүй байна.**

ИТХурал, Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Ахлах сургууль, Соёлын төвд 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт гаргажээ.

Өлгий сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар Сангийн сайдын 2012 оны 11-р сарын 15-ны өдрийн 238 тоот тушаалын 2,2-д "...орон нутгийн төсвийн байгууллагын хувьд аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дараа жилийн төсвийн багцад тус тус тусгаж батлуулна гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах. Төсвийн тухай хуулийн 57,3-д "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлэх зөвлөмж өгч зөрчилгүй санал дүгнэлт гаргасныг хэрэгжүүлж ажилласан байна.

УВААГ-2016/06-НА

Өлгий сумын төсөвт байгууллагуудыг нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй санал дүгнэлт гаргажээ.

Аудитын газар 2012, 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2014 оны 5 сард нийцлийн аудит хийж 360,8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх, 33508,2 мянган төгрөгийг сум, байгууллагын дансанд оруулах 12 акт, 1725,0 мянган төгрөгийн зөрчил арилгуулах 1 албан шаардлага өгснөөс 590,0 мянган төгрөгийн актыг хууль хяналтын байгууллагад шилжүүлснээс бусад акт, албан шаардлагыг бүрэн барагдуулсан байна.

#### **2.4. Мэдээллийн самбарт шилэн дансны мэдээллийг байршуулжээ.**

Шилэн дансны тухай хуулийн 5.7-д “Орон нутгийн төсөв, түүний төсвийн захирагчийн шилэн дансны мэдээллийг энэ хуулийн 5.1-д заасан цахим хуудастай эсэхээс үл хамааран тухайн байгууллагын мэдээллийн самбарт байрлуулна” гэж заажээ.

Сумын төсөвт байгууллагууд дээрх заалтын дагуу төсвийн мэдээ тайлангаа болон бусад мэдээллийг байгууллагын самбарт тухай бүр байршуулсан байна.

## Бүлэг 3

### Эмийн эргэлтийн сангаас зориулалт бус зардал гаргажээ.

#### 3.1. 2015 онд Эргэлтийн эмийн сан алдагдалтай ажиллажээ.

Эмийн эргэлтийн сан нь Төрийн банкинд харилцах данстай сумын Засаг дарга 1-р гарын үсгийг, сумын Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч 2-р гарын үсгийг зурж захиран зарцуулсан байна.

Эмийн эргэлтийн сан 2014 онд 28177,5 мянган төгрөгийн орлого олж, 26354,9 мянган төгрөгийн зардал гаргаж 1822,7 мянган төгрөгийн ашигтай, 2015 онд 26233,8 мянган төгрөгийн орлого олж, 28344,3 мянган төгрөгийн зардал гаргаж 2110,5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Дансанд байгаа бэлэн мөнгө, эм боох материалын үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

| Он             | Бэлэн мөнгө | Эм боох материал |
|----------------|-------------|------------------|
| 2014 оны эхэнд | 6505,6      | 6877,4           |
| 2015 оны эхэнд | 5063,2      | 10586,4          |
| 2016 оны эхэнд | 2812,2      | 10027,0          |

#### 3.2.Эмийн худалдан авалтыг хууль журмын дагуу зохион байгуулсан байна.

2014 онд 23155,8 мянга, 2015 онд 24817,2 мянган төгрөгийн эм, боох хэрэгсэл худалдан авчээ.

Эрүүл мэндийн төвийн зайлшгүй шаардлагатай эмийн захиалгыг жил бүр аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн худалдан авалтын үйл ажиллагааг зохион байгуулжээ. Тендерийн захиалгат эмийн нийлүүлэлтийг аймгийн Эрүүл мэндийн газраас хийж байна.

Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмын 3.3.1-д заасны дагуу тендерийн захиалгад ороогүй эм болон сум, багийн хүн амын хэрэгцээт зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг Эмийн эргэлтийн сангийн хөрөнгөөр холбогдох эм хангамжийн байгууллага, эмийн сангаас шууд худалдан авалтыг хийжээ.

#### 3.3.Эргэлтийн эмийн сантай холбоотой өглөг авлагыг бүрэн тайлагнасан байна.

2015 оны тайлангаар 2143,8 мянган төгрөгийн авлагатай, 738,8 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарч авлага, өглөгийг бүрэн барагдуулан ажилласан байна.

Эмийн эргэлтийн сангийн хөрөнгөнд хяналтын тооллого хийхэд 2912,8 мянган төгрөгийн эм боох материалыг бусдад зээлдүүлсэн байсныг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.4-д “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ.

Санаатайгаар идэж ашигласан буюу дутагдуулсан нь илэрвэл хуулийн этгээдийн эрх баригч уг хэргийг 7 хоногийн дотор хуулийн байгууллагад шилжүүлнэ” гэж заасныг үндэслэн төлүүлэхээр акт тогтоолоо.

### 3.4.Эргэлтийн эмийн сангаас Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны зардалд хөрөнгө зарцуулсан байна.

Эмийн эргэлтийн сангийн хөрөнгийг зориулалтын үйл ажиллагаанд дараах байдлаар зарцуулжээ. Үүнд:

/ мянган.төг/

| Үзүүлэлт                        | Томилолт, унааны зардал | Бензин шатахуун | Авто машины сэлбэг хэрэгсэл | Урсгал засвар | Компьютер, техник хэрэгсэл програм хангамж | Бичиг хэрэг | Магадлан итгэмжлэл | Сургалт унааны зардал | Бусад зардал |
|---------------------------------|-------------------------|-----------------|-----------------------------|---------------|--------------------------------------------|-------------|--------------------|-----------------------|--------------|
| 2014 онд                        | 42.0                    | 284.8           | 1,475.0                     | 150.0         | 157.0                                      | 162.2       | 450.0              | 20,0                  | 14.0         |
| 2015 онд                        | 56.0                    | 356.0           |                             | 160.0         |                                            |             |                    | 2330.2                | 120.0        |
| 2016 оны 9 сарын 20-ны байдлаар |                         | 210.6           |                             | 107.5         | 198.0                                      | 86.0        |                    |                       | 25.0         |
| Дүн                             | 98.0                    | 851.4           | 1,475.0                     | 417.5         | 355.0                                      | 248.2       | 450.0              | 2,350.2               | 159.0        |

Эрүүл мэндийн газрын даргын 2013 оны А/62 тоот тушаалаар баталсан “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журмыг” зөрчиж Эрүүл мэндийн төвийн автомашины урсгал засварт 1475.0 мянга, магадлан итгэмжлэлийн зардалд 450.0 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Цаашид эмийн эргэлтийн сангийн журмыг мөрдөж ажиллахыг зөвлөв.

Нийцлийн аудитаар 3602.7 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 4 зөвлөмж өглөө.

## Холбогдох байгууллагын санал

  
УВС АЙМАГ  
ӨЛГИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
313409, Төгрүг, Өлгий сум

2016.10.10 № 105  
Тусгай \_\_\_\_\_ Үндс № \_\_\_\_\_

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын 2014, 2015 оны төсөвт байгууллагуудын санхүүгийн баримтанд аудит хийгдсэн холбогдох материалтай танилцаад санал нэгтэй байгаа харин ахлах сургуульд тавигдсан багш Ц. Отгонцэцэгт зэргийн нэмэгдэл олгосон 506160 төгрөгтэй актыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул холбогдох материалыг хавсаргаж хүргүүлэв.

ДАРГА  Д. ВАНЧИНХҮҮ

### **Холбогдох байгууллагын ирүүлсэн саналд өгөх тайлбар**

Өлгий сумын Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 105 дугаартай албан тоотоор аудитын тайланд ирүүлсэн саналд тайлбар өгөх шаардлагагүй гэж үзлээ.

Харин багш Ц.Отгонцэцэгт олгосон зэргийн нэмэгдлийг төлүүлэх төлбөрийн актын төслийг нотлох баримт үндэслэн удирдлагын зөвлөлөөр хүчингүйд тооцож шийдвэрлэлээ.

## Дүгнэлт

Энэхүү нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.Үүнд:

1. Төсөвт байгууллагууд оны эхэнд ажиллагсдын цалинг сүлжээ, шатлал, олгогдох нэмэгдэл цалингийн хувь хэмжээг тогтоож тушаал гаргаагүй байна.
2. Эрүүл мэндийн төв жолоочийн замын хуудсыг тухай бүрд нь хөтөлж шатахуун зарцуулалтын тооцоог бодоогүй, ЗДТГазар замын хуудсыг нөхөж хөтлөн, тооцоог дутуу бодсон, бусад байгууллагууд замын хуудас хөтлөж тооцоо бодоогүй байна.
3. Төсөвт байгууллагууд хэрэглэсэн гэрэл цахилгааны төлбөрийг тоолуурын заалтгүй нэхэмжлэлээр гүйцэтгэсэн байна.
4. ЗДТГазар 2015 онд 3 худгийн мотор худалдан авсан ба хуучин ашиглагдаж байсан худагны моторууд ажиллахгүй болсон шалтгааныг техникийн акт үйлдэхгүйгээр шинэчлэн тавьсан байна.



## Зөвлөмж

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дор дурьдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна. Үүнд:

**Өлгий сумын Засаг дарга Д.Ванчинхүү, төсөвт байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарт**

1.Оны эхэнд орон тоо, цалингийн сандаа багтаан ажиллагсдын цалин, нэмэгдэл цалингийн хэмжээг тушаалаар батлах.

2. Жолоочийн замын хуудсыг тухай бүрд нь хөтөлж шатахуун зарцуулалтын тооцоог бодож байх.

3. Төсөвт байгууллагуудад хэрэглэсэн гэрэл цахилгааны төлбөрийг тоолуурын заалт бичигдсэн нэхэмжлэлээр гүйцэтгэж, бичилтэнд хяналт тавьж ажиллах.

4. Техник хэрэгсэл эвдэрч ажиллахгүй болсон тохиолдолд Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр дүгнэлт гаргуулж ажиллах.

ТАЙЛАН БИЧСЭН: АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

ШИНЖЭЭЧ

С.АЛТАНХУНДАГА

М.БАТ-АМГАЛАН

Л.БАТ-ОЧИР